



ЭЛХАГВАСҮРЭН

Захиргааны хэргийн
анхан шатны 20 дугаар
шүүхийн шүүгч

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын шинэ Үндсэн хуульд⁴⁸ “*... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно*” гэж заасны дагуу 2004 онд Улсын Их Хурлаас захиргааны хэргийн дагнасан шүүхийг анх байгуулснаас хойш өдгөө 10 жилийн хугацаа өнгөрчээ.

Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэрийг ийнхүү дагнасан шүүхийн хяналтад оруулснаар тэдгээрийн дур зоргын үйлдлээс иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдөхөөс хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх нөхцлийг бүрдүүлсэн юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүх нийт 7441 хэрэг⁴⁹ шийдвэрлэсний 61,1% буюу 4546 хэргийг нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн талд шийдвэрлэсэн байна.

Гэхдээ энэ нь зөвхөн шүүхийн шийдвэрийн хүрээнд гаргасан статистик үзүүлэлт. Магадгүй үүний цаана хэд нь бодитоор биелэгдэгдэж сэргэсэн, хэд нь

“цаасан” дээр буусан формаль эрх болох нь эргэлзээтэй.

Жишээ нь, 2011 онд улсын хэмжээнд захиргааны хэргийн шүүхийн 161 шийдвэрт албадан гүйцэтгэх хуудас бичигдсэнээс шийдвэр бүрэн биелэгдсэн 87 буюу 54,0%, биелэгдээгүй 66 буюу 41,0%, нэхэмжлэгчийн хүсэлтээр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон 8 буюу 5%, мөн 2012 оны байдлаар захиргааны хэргийн шүүхийн 97 шийдвэрт гүйцэтгэх хуудас бичигдсэнээс шийдвэр бүрэн биелэгдсэн 34 буюу 35,0%, биелэгдээгүй 62 буюу 63,9%, нэхэмжлэгчийн хүсэлтээр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон 1 буюу 1%, гэсэн судалгаа байдаг.

Шалтгааныг нь эс тооцвол эдгээр тоо баримт захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт, түүний гүйцэтгэх ажиллагаа ямар түвшинд явагдаж байгааг илтгэнэ.

Жилээс жилд захиргааны хэргийн шүүхэд хандах иргэд, хуулийн этгээдийн тоо өсөн нэмэгдсээр байгааг шүүхээс гарч буй шийдвэрийн чанартай холбон тайлбарлаж болох ч гарсан шийдвэрийн хэрэгжилт урвуу хамааралтай байх аваас шүүхэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр хандсаны, шүүхээс маргаан хянан шийдвэрлэсний ач холбогдол, үр дагаврыг үгүйсгэнэ.

Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нийтийн захиргааны хүрээнд зөрчигдөхөөс хамгаалах, сэргээн тогтоох нэн тэргүүний чиг үүрэгтэй, хянан шийдвэрлэх маргааны бие даасан харьяалалтай, хэргийн оролцогчдын өвөрмөц бүрэлдэхүүнтэй, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үе шатыг

⁴⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэххэсэг УБ. 1992 он

⁴⁹ Шүүх эрх мэдэл сэтгүүл №2 УБ. 2014 он. 25 дахь талаас дэлгэрүүлжээ.

угтуулсан процессийн журамтай, нотолгооны үүргийг өөрөө хариуцан биелүүлэх тусгай зарчимтай захиргааны хэргийн шүүхийн тухайд ийнхүү хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх, тэр тусмаа шийдвэр гүйцэтгэлийн шатанд биелэгдэхгүй байх явдал нийгэмд бугшсаар байгаа нь алсдаа дагнасан шүүхэд итгэх иргэдийн итгэл, шүүхийн нэр хүнд, үүрэг зорилгыг алдагдуулах, мөн чанарыг нь үгүйсгэх сөрөг үр дагавартай.

Ганцхан жишээ дурдахад, захиргааны албан тушаалтан Шүүхийн Шийдвэрийг биелүүлснийхээ “төлөөс”-нд өөртэй заргалдсан албан хаагчыг 5 удаа ажлаас халж, тухай бүр гаргасан шийдвэрийг нь шүүхээс хүчингүй болгож байсныг хэрхэн ойлгох вэ.

Өөрт таалагдаагүй шүүхийн шийдвэрийг бөмбөг тоглож байгаатай адил “өшиглөж”, таалагдсан шийдвэрийг адис авч буй мэтээр ёсчлон биелүүлэх захиргааны байгууллага, албан тушаалтныг ёс зүйтэй, төрийн түшээ гэж үзэх үү.

Үндсэндээ иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг цаасанд буусан шүүхийн шийдвэрээр бус харин амьдралд бодитоор хэрэгжүүлэх, гарсан шийдвэр болгон ягштал хэрэгжих тийм л эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлага болжээ.

Нотолгооны үүргийг хэргийн оролцогчид бус өөрөө дагнан гүйцэтгэдэг захиргааны хэргийн шүүхийн тухайд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа багагүй хугацаанд үргэлжилдэг. Төдийлэн элбэг биш ч зарим тохиолдолд маргааны

ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан хэдэн жил үргэлжлэх явдал ч гарах нь бий.

Гэвч энэ бүхний эцэст шүүхээс гарсан шийдвэр хэлбэрэлтгүй хэрэгждэг байх нь юу юунаас чухал. Зарим тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн процессийн хугацаанаас ч удаан үргэлжлэх, заримдаа үүнээс ч дор огт биелүүлэхгүй байх тохиолдол гарсаар байна.

Захиргааны хэргийн шүүхийн хариуцагч болох төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй, эсхүл биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж, тухайлбал:

-төрийн албанаас хууль бусаар халагдсан албан хаагчийг урьд эрхэлж байсан албан тушаалд нь эгүүлэн тогтоосон;

-хууль бусаар явагдсан тендерийг хүчингүй болгож, уг тендерийг дахин зарлах, үнэлэхийг даалгасан;

-хэргийн нөхцөл байдлыг дахин шалгаж шинээр захиргааны акт гаргах хүртэл тухайн маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлсэн зэрэг шүүхийн шийдвэрүүдийг илүүтэйгүүр хэрэгжүүлэхгүй уландаа гишгэх байдал нийгэмд байсаар байна.

Аливаа хэрэг, маргааныг үүсэхээс нь өмнө эцэслэн шийдвэрлэх хүртэл, бас шийдсэний дараа ч ихээхэн ажил ундардаг нь тодорхой. Тэгвэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг энэ мэтчилэн хэрэгжүүлэхгүй байх нь ардчилсан эрх зүйт төрд байж боломгүй “гаж үзэгдэл” гэлтэй.

Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан, эдийн засгийн хувьд оршихуйн үндэс болсон хувийн өмчид хүртэл шүүхийн шийдвэрээр “халдах” явдал байдагт хэн ч цочирддоггүй. Гэтэл өмчилж боломгүй тэрхүү албан тушаалын эрх мэдэлд халдсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх шалтгаан нөхцөл юунд байна вэ.

“Хааны алба халаатай, эзний алба ээлжтэй” гэдэг зүйр үг бий. Элдэв дүрэм журам, тушаал, шийдвэр гаргаж, түүнийгээ мөрдөхийг шаарддаг, магадгүй эс биелүүлсэн тохиолдолд хариуцлага хүртэл хүлээлгэдэг атлаа өөрт нь чиглэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг зөвтгөж бодоход ч эрүүл ухамсарт төсөөлөгдөмгүй.

Энэ бүхний шалтгаан нь “объектив” гэхээс илүүтэйгүүр ердөө л “субъектив” хүчин зүйл. Өөрийнх нь гаргасан шийдвэрийг шүүх хүчингүй болгосонд эгдүүцэж, захиргааны шинэ акт гаргахыг даалгах байдлаар “албан тушаалын” эрх хэмжээнд нь халдсанд бухимдаж, нөгөө талаас нэхэмжлэгчид дийлдсэндээ шаралхаж, эцэст нь гарсан шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй байх, хэлбэрийн төдий биелүүлэх байдлаар иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бодитоор сэргээхгүй байгаа нь захиргааны байгууллага, албан тушаалтны бодит дүр зураг.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчин, өнөөгийн байдал.

Шүүхийн шийдвэр тухайн маргааны хувьд эрх зүйн дээд хүчин чадалтай, эцсийн

бөгөөд заавал биелэгддэг байх шинжийг өөртөө агуулдаг тул хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчид сайн дураар биелүүлэхгүй байх тохиолдолд албадан гүйцэтгэх ажиллагаа явагдах шаардлага гардаг боловч төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд энэхүү албадлагыг хэрэглэж тэдгээрээс шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг шаардана гэдэг нилээд хүндрэлтэй, бэрхшээлтэй, асуудлыг нэг болжээ.

Үнэндээ төр түүнийг төлөөлсөн албан тушаалтны эрх зүйн байдал, чиг үүрэг, эрх ямба нь холбогдох салбар хуулиудаар зохицуулагдсан байдаг бол жирийн иргэн, хуулийн этгээдэд тийм боломж, нөхцөл байхгүй учраас албан тушаалтны хувьд эрх мэдлээр дулдуйдаж шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх магадлал их.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан гүйцэтгэнэ гэж заасан.

Гэтэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлд “...захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр...” гэснээс өөрөөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалт нь нэр томъёоны хувьд ч тухайлбал төлбөр авагч, төлбөр төлөгч гэх зэргээр хэрэгжүүлэх арга журмын хувьд ч захиргааны хэргийн шүүхээс гаргаж буй шийдвэрийг хэрэгжүүлэх процедуртай төдийлэн нийцдэггүй.

Тийм ч учраас өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд албадан гүйцэтгэх хуудас бичигдсний дараахь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа үндсэндээ уг шийдвэрийг биелүүлэхийг “хүссэн” албан бичгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагаас холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх төдийхнөөр хязгаарлагдаж байна.

“Хүссэн” гэж тодотгосны тухайд жишээ нь, Эрүүгийн хэргийн хувьд хүсэх бус, төрийн албадлага хэрэглэх байдлаар ялтанд хорих ялыг биеэр эдлүүлж, цээрлүүлдэг, иргэний хэргийн хувьд мөн л хүсэх бус төлбөр төлөгчийн харилцах дансыг хаах, хөрөнгийг битүүмжлэх, дуудлага худалдаа явуулах гэх зэргээр бас л албадлагын журмаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хэрэгждэг.

Хэдийгээр захиргааны хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд хүлээлгэсэн эрүүгийн хариуцагыг биелүүлж буй арга, хэлбэрээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг албадан явуулах нь зохимжгүй чөнөөгийн эрх зүйн зохицуулалтын бодит нөхцөл байдал нэг талаас шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байж болдог гэсэн ойлголтыг тухайн захиргааны албан тушаалтанд төрүүлээд зогсохгүй, нөгөө талаас шүүхэд үл итгэх, шүүхийг үгүйсгэх, сөрөг үр дагаврыг эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээдэд, цаашлаад нийгмийн сэтгэл зүйд бий болгох аюултай.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн төрлийг нэг бүрчлэн зааж өгсөн. Тэдгээрээс “захиргааны байгууллага,

албан тушаалтнаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчлөх, хасах” тухай шийдвэр нь мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг хэрэглэх боломжтой.

Харин “маргаан бүхий захиргааны актыг хүчингүй” болгосноор нэгэнт шүүхээс хүчингүй болгосон тухайн актыг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин хүчингүй болгох үндэслэлгүй мэт, өөрөөр хэлбэл хүчингүй болгосон шийдвэрийг хүчингүй болгох ойлголт байж боломгүй.

Мөн төлбөр тогтоосон актын тухайлбал, татварын улсын байцаагчийн актын төлбөрийн хэмжээг багасгасан шийдвэрт гүйцэтгэх ажиллагаа явуулах шаардлагатай эсэх нь эргэлзээтэй.

Эдгээрийг онцлохын цаад санаа нь угтаа ямар нэгэн акт гаргахыг даалгасан буюу захиргааны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосон шүүхийн шийдвэрийн хүрээнд гүйцэтгэх ажиллагаа явагдах нь зохимжтой.

Өөрөөр хэлбэл захиргааны акт “илт хүчин төгөлдөр бус болохыг”, эсхүл “эрх зүйн харилцаа байгаа болохыг” тогтоосон шүүхийн шийдвэрийн дийлэнх нь захиргаанд ямар нэгэн үүрэг болгосон зохицуулалт тусгагдаггүй.

Гэвч захиргааны актыг илт хүчин төгөлдөр бус гэдгийг шүүх тогтоосноор уг акт анхнаас гарах учиргүй, иймд түүнийг хэрэгжүүлэхгүй байх боломжтой зэрэг үр дагавар үүсэх болов ч жишээ нь, хуулиар олгогдоогүй, эрх мэдлээ хэтрүүлж гаргасан

албан тушаалтны шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд илт хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсан ч уг тушаалыг тухайн албан тушаалтан өөрөө хүчингүй болгохгүй байх магадлалтай.

Иймд захиргааны шүүхийн зарим шийдвэрт онолын хувьд гүйцэтгэх ажиллагаа хийгдэх шаардлагагүй ч мэт боловч албадлагын ямар нэгэн ажиллагаа хийгдэхгүйгээр иргэн, хуулийн этгээдийн зерчигдсөн эрхийг бодитоор сэргээгдэхгүй байх нөхцлийг захиргааны байгууллага, албан тушаалтнууд өөрсдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхгүйгээр гаргасаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлохдоо “иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага” байна гэж заажээ.

Харамсалтай нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг нарийвчлан журамлаагүй, зохицуулалт дутмаг байгаа одоогийн нөхцөлд энэхүү төрийн байгууллагаас захиргааны хэргийн шүүхийн хариуцагч болох гүйцэтгэх эрх мэдлийн бусад байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд тухайн шийдвэрийг биелүүлэх албадлага хэрэглэх боломж бүр ч хомс юм.

Түүнчлэн Орон нутгийн шийдвэр гүйцэтгэх алба нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартаа харъяалагддаг, өөрөөр хэлбэл удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний бодлого, цалин хөлс гэх зэргээр тухайн нутаг дэвсгэрийн захиргааны байгууллагаас

хамааралгүй боловч өнөөдрийн байдлаар жишээ нь, аймгийн Засаг даргад шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг албадана гэдэг гүйцэтгэгч нарын хувьд зүйрлэхэд “муурын сахлаар оролдсон хулганатай адил” байгааг нуух юун.

Нэг зүйл тэмдэглэхэд, энд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн албан тушаалтныг буруутгах бус гагцхүү захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн зохицуулалт ямар байгааг илэрхийлэхийг зорьлоо.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

Давын өмнө шүүхээс гарч буй гүйцэтгэх ажиллагаа хийгдэх боломжтой шийдвэрийг:

1-рт: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, /жишээ нь маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн/,

2-рт: Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол /нэхэмжлэгч хариуцагч эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүлээн зөвшөөрсныг тус тус баталсан/,

3-рт: Шүүхийн шийдвэр /маргааны үйл баримтад дүгнэлт өгөх байдлаар хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол/ гэж тус тус ангилж болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг боловсронгуй болгох хүрээнд эдгээр шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг албадан биелүүлэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэх байгууллагаас холбогдох албан тушаалтанд тухайн шийдвэрийг биелүүлэх тодорхой хугацаа заасан мэдэгдлийг хүргүүлэх;

Мэдэгдэлд заасан хугацааг хариуцагчаас шаардлагатай гэж үзвэл нэг удаа тодорхой хугацаагаар сунгуулах;

Тогтоосон хугацаа өнгөрсний дараа торгуулийн арга хэмжээ авах /Энэ тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцох уу, эсхүл тухайн албан тушаалтны цалингийн хэмжээнээс тооцох уу, мөн хэдэн хувиар тооцох/;

Эцэст нь томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж шүүхийн шийдвэр биелүүлээгүй тухайн албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөх хүсэлтийг гаргах зэргээр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн харилцааг төгөлдөржүүлэх боломжтой.

Тухайлбал, торгуулийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх зэрэг харилцааг Захиргааны хариуцлагын тухай хуулиар; Шүүхийн Шийдвэр биелүүлээгүй албан тушаалтныг торгох шийдвэр гаргах, тухайн албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх санал гаргах зэрэг харилцааг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар; эдгээр шийдвэрийг биелүүлэх, шийдвэр биелүүлэх хугацааг сунгах зэрэг харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тус тус зохицуулж болно.

Түүнээс гадна иргэний хэргийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаан дахь гүйцэтгэгчийг урамшуулах механизм захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хэрэгжих боломжтой эсэх, шаардлагатай гэж үзвэл урамшууллыг хэрхэн тооцож, гаргуулах, нэр томъёоны хувьд шийдвэр гүйцэтгэлийн шатанд захиргааны хэргийн оролцогчдыг зөв тодорхойлох нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд зайлшгүй шийдвэрлэгдэх асуудлуудын нэг болно.

Эцэст нь “бурууг бусдаас хайх бус” бас шүүхээс гарч буй шийдвэр хэрэгжих боломжтой, түүнд хэрэгжүүлэх арга замыг тодорхой заасан байх нь тухайн шийдвэр биелэгдэх анхдагч нөхцлийг бүрдүүлдэг гэдгийг мартаж болохгүй.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоос гадна тухайн биелүүлүүлэх гэж буй шийдвэрээс шууд хамааралтай ойлголт бөгөөд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлд шүүгч гаргаж буй шийдвэртээ түүнийг гүйцэтгэх арга, журмыг тодорхойлж байхаар тусгасан байдаг.

Шинээр захиргааны акт гаргахыг даалгасан шийдвэрт хэргийн нөхцөл байдал, холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтаас хамаарч уг шийдвэрийг гаргах боломжит хугацааг тогтоож өгөх нь үүний тодорхой жишээ юм.

Хуулинд ард түмэн зориулагдах бус, харин ард түмэнд хууль зориулагдах ёстой гэж хэлц үг байдаг. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчлэлийн

хүрээнд ус агаар мэт шаардлагатай байгаа захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр олон улсын туршлага судлах, харилцан мэдээлэл солилцох бололцоог Та бидэнд хангаж байгаад энэхүү онол, практикын бага хурлын бас нэгэн зорилго, ач холбогдол орших болов уу.

**Б.СҮХ-ОЧИР**

Монголын Мэргэжлийн
Нийгмийн Ажилтны
Нийгэмлэгийн захирал,
Улаанбаатар Их
Сургуулийн нийгмийн
ажлын багш, нийгмийн
ажлын магистр

**БОДИТ ЖИШЭЭТЭЙ АЖИЛЛАХ
АРГА ЗҮЙ**

Түүхэн хөгжлийн явцад нийгмийн ажил хувьсан өөрчлөгдөж, хөгжсөөр мэргэжил болтлоо төлөвшжээ. Нийгмийн ажлын мэргэжлийн хөгжлийг дараах үндэслэлээр тайлбарлаж болно. Үүнд:

1. Хүмүүсийн хамтын амьдралын харилцаанаас үүссэн олон асуудал нь нийгмийн ажлын хурдацтай хөгжлийн голтүлхэц юм. Өөрөөр хэлбэл янз бүрийн соёл, нийгэмд аж төрөх ёсны харилцан адилгүй нөхцөлд урган гарч буй аливаа асуудлыг шийдэх явцад нийгмийн ажил улам боловсронгуй болж, салбарлан хөгжсөөр байна.

2. Хүмүүсийн хэрэгцээ, нийгмийн хөгжил, өөрчлөлтөнд тулгуурлан хувьсан өөрчлөгдөж байдаг. Нийгмийн ажлын энэ шинж нь нийгмийн шинжлэх ухааны онцлог юм. Нийгмийн ажил бол үнэт зүйл, онол, практик хосолсон цогц систем юм.

Харин манай оронд 1996 оноос хүүхэд хамгааллын, 1999 оноос боловсролын, 200 оноос хорооны, 2004 оноос хорих ангийн, 2007 оноос халамжийн, 2008 оноос эрүүл мэндийн салбарын нийгмийн ажилтнууд бий болон өөр өөрсдийн онцлогийг тусган хөгжиж байгааг та бүхэн мэднэ.

Нийгмийн ажлын мэргэжилд онол, практикийг салангид ойлгож болохгүй. Практик гэдэг нь онол, мэдлэгээ амьдралд хэрэгжүүлэн тодорхой өөрчлөлтийг авчирч байгаа үйл ажиллагаа юм. Нийгмийн ажлын